

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	5
2.9. Зорилтот түвшний биелэлт	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
3. Менежментийн захидал	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2.Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	10
4.3.Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО
ҮЦК ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
О.ЭРДЭНЭГЭРЭЛ ТАНАА

2020.03.13 № 06/805
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтад заасны дагуу Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн гүйцэтгэх захирал О.Эрдэнэгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд хийлээ.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Юнистар аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангаа 2020 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 01/26 дугаар бүхий албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн нэгэн гол хэсэг бүрэлдэхүүний хувьд, үнэт цаасны арилжааны дараах клиринг, төлбөр тооцоог шуурхай, найдвартай, тасралтгүй гүйцэтгэж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг үзүүлэхэд оршино.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд.

- Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа
- Үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулинд өөрчлөлт орсон.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн “СоларСис” программ хангамж ашиглаж байна.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад эрсдэл бага байсан тул дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 16 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллагийн хувь хэмжээг 1.0 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,337.6 сая төгрөгөөс тооцон 13.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 292.6 сая төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна. Оны эхнээс дансны авлага 15.6 дахин, үндсэн хөрөнгө 58.0 хувь, биет бус хөрөнгө 8.5 дахин өссөн байна. Харин мөнгөн хөрөнгө 8.8 хувиар, урьдчилж төлсөн зардал тооцоо 100 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,806.1	5,294.2	(511.9)
Авлага	5.6	93.7	88.1
Бусад авлага	0.02	-	(0.02)
Бараа материал	0.34	0.35	0.01
Урьдчилж төлсөн зардал тооцоо	0.6	-	(0.6)
Үндсэн хөрөнгө	57.8	91.3	33.5
Биет бус хөрөнгө	11.4	108.6	97.2
Хойшлогдсон татварын хөрөнгө	1.9	2.8	0.9
Нийт хөрөнгө	5,883.7	5,591.1	(292.6)
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,013.6	467.1	(546.5)
Урт хугацаат өр төлбөрийн дүн	1.9	2.8	0.9
Эздийн өмч: - төрийн	4,000.0	4,000.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	9.6	9.6	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	858.6	1,111.6	253.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,883.7	5,591.1	(292.6)

Мөнгөн хөрөнгө 511,9 сая төгрөгөөр буурсан нь 100.0 сая төгрөгөөр программ хангамж, 56,4 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан, төрийн өмчийн ногдол ашиг 120,8 сая төгрөг төлсөн зэрэг шалтгаантай.

Дансны авлага 15.6 дахин буюу 88.1 сая төгрөгөөр өссөн нь хадгаламжийн хүүгийн тайлант хугацааны авлага тооцоолж бүртгэсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр 546.5 сая төгрөгөөр буюу 53.9 хувиар буурсан. Энэ нь 49.9 сая төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулж, арилжаанд оролцогчдод өгөх өглөг 492.2 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

2.9. Зорилтот түвшний биелэлт

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК нь тайлант онд 1,020.5 сая төгрөгийн нийт орлоготой, 567.4 сая төгрөгийн нийт зардалтай ажиллаж 407.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөжээ. Гүйцэтгэлээр 991.6 сая төгрөгийн нийт орлоготой, 536.0 сая төгрөгийн нийт зардалтай ажиллаж орлогын төлөвлөгөө 97.2 хувийн, зардлын төлөвлөгөө 94.5 хувийн биелэлттэй гарсан байна. Гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөө 2.8 хувиар тасарсан нь хувьцааны клирингийн шимтгэл 32.4 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна. Төрийн өмчийн ногдол ашигт 120.8 сая төгрөг төлсөн. Борлуулалтын 1 төгрөгт 0.56 төгрөгийн зардал гаргах зорилт тавьсан бол гүйцэтгэлээр 0.53 төгрөгийн зардал гаргаж ашигт ажиллагааны түвшин өссөн байна. Тайлант онд 426.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт төлөвлөснөөс гүйцэтгэлээр 156.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 270.0 сая төгрөгийн хөрөнгийн зардал гараагүй байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 16 эрсдэл тодорхойлж, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл нэмж тодорхойлон нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой зөрчил илэрснийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.1 дахь заалтад хамаарах байтал 3.1.3 дахь заалтад хамааруулан эрх олгосноос зөвхөн хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний мэдээлэл оруулсан байна. Нийт 60 мэдээлэл оруулснаас 49 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2019 оны санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан асуудлууд нь цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Хуулийн хэрэгжилт

1.1 Илрүүлэлт:

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д хамаарах байтал 3.1.3 дахь заалтад хамааруулан эрх олгосноос зөвхөн худалдан авах ажиллагаа, том дүнтэй гэрээ хэлцлийн мэдээлэл оруулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 6 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл: Хууль хэрэгжихгүй байх, төрийн өмчийн ил тод байдал хангагдахгүй байх, хяналт сулрах.

1.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох байгууллагад хандаж шилэн дансны эрхээ нээлгэх, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг уг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь бүрэн мэдээлж байх, цаашид хууль зөрчихгүй ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Сангийн яамнаас өгсөн цахим мэдээлэл оруулах эрхийн хүрээнд мэдээллээ оруулж байгаа. Тайлан зөвлөмжийг зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
А	Б		
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	5,806,051,621.88	5,294,218,258.24
1.1.2	Дансны авлага	5,621,917.81	93,726,849.31
1.1.4	Бусад авлага	19,852.00	
1.1.6	Бараа материал	336,700.00	348,420.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	595,630.63	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,812,625,722.32	5,388,293,527.55
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	57,778,519.97	91,332,424.73
1.2.2	Биет бус хөрөнгө	11,437,603.20	108,640,605.63
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,914,881.40	2,822,691.31
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	71,131,004.57	202,795,721.67
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,883,756,726.89	5,591,089,249.22
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	810.00	69,597.22
2.1.1.3	Татварын өглөг	58,491,150.48	8,889,588.84
2.1.1.4	НДШ-ийн өглөг	460,000.00	40,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	954,699,704.48	458,054,289.12
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,013,651,664.96	467,053,475.18
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,914,881.40	2,822,691.31
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,914,881.40	2,822,691.31
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,015,566,546.36	469,876,166.49
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч : - төрийн	4,000,000,020.75	4,000,000,020.75
2.3.6	Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдэл	9,560,000.00	9,560,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	858,630,159.78	1,111,653,061.98
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,868,190,180.53	5,121,213,082.73
2.3.20	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,883,756,726.89	5,591,089,249.22

4.2.Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөг/	
		2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,018,830,521.28	642,508,173.59
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	1,018,830,521.28	642,508,173.59
4	Арилжааны шимтгэлийн орлого		642,508,173.59
5	Хүүний орлого	318,809,599.58	348,810,826.21
8	Бусад орлого	49,000.00	346,500.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	416,857,794.82	520,699,267.09
12	Бусад зардал	22,174,710.00	16,136,862.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	19,656.00	
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-72,419.48	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	898,603,852.56	454,829,370.71
19	Орлогын татварын зардал	92,750,762.91	46,188,813.36
20	Татварын дараах ашиг (алдагдал)	805,853,089.65	408,640,557.35
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	805,853,089.65	408,640,557.35
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	805,853,089.65	408,640,557.35
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3.Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2017 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	4,000,000,020.75		72,445,329.91	4,072,445,350.66
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(7,395,289.78)	(7,395,289.78)
2	Залруулсан үлдэгдэл	4,000,000,020.75	-	65,050,040.13	4,065,050,060.88
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			805,853,089.65	805,853,089.65
6	Зарласан ногдол ашиг			(12,272,970.00)	(12,272,970.00)
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		9,560,000.00		9,560,000.00
8	2018 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	4,000,000,020.75	9,560,000.00	858,630,159.78	4,868,190,180.53
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(34,739,691.70)	(34,739,691.70)
2	Залруулсан үлдэгдэл	4,000,000,020.75	9,560,000.00	823,890,468.08	4,833,450,488.83
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			408,640,557.35	408,640,557.35
6	Зарласан ногдол ашиг			(120,877,963.45)	(120,877,963.45)
8	2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	4,000,000,020.75	9,560,000.00	1,111,653,061.98	5,121,213,082.73

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,001,905,496,148.60	645,301,788.59
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	800,438,152.93	642,508,173.59
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		2,447,115.00
	Бусад мөнгөн орлого	2,001,105,057,995.67	346,500.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,002,558,250,374.06	1,228,696,768.99
	Ажиллагчдад төлсөн	220,231,625.47	312,126,148.55
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	60,138,448.19	74,854,825.30
	Бараа материал худалдан авахад төлсөн	6,373,920.00	7,479,250.00
	Ашиглалтын зардалд төлсөн	19,187,467.18	19,070,367.90
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,443,740.00	6,879,000.00
	Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн		311,835,450.22
	Татварын байгууллагад төлсөн	62,699,378.36	121,910,017.46
	Бусад мөнгөн зарлага	2,002,186,175,794.86	374,541,709.56
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-652,754,225.46	-583,394,980.40
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	310,868,900.22	348,810,826.21
	Хүлээн авсан хүүний орлого	310,868,900.22	348,810,826.21
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	28,446,358.37	156,371,246.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	17,646,358.37	156,371,246.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,800,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	282,422,541.85	192,439,580.21
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	12,272,970.00	120,877,963.45
	Төлсөн ногдол ашиг	12,272,970.00	120,877,963.45
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-12,272,970.00	-120,877,963.45
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-382,604,653.61	-511,833,363.64
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,188,656,275.49	5,806,051,621.88
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,806,051,621.88	5,294,218,258.24

5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр	2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код
2020.03.12			САГ-2020/26/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК		Сая төгрөгөөр

дд	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул агаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	3	4	5	8	9
1	Тус компани нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д хамаарах байтал 3.1.3 дахь заалтад хамааруулан эрх олгосноос зөвхөн худалдан авах ажиллагаа, том дүнтэй гэрээ хэлцлийн мэдээлэл оруулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 6 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.	-	Зөвлөмж өгсөн.	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	О.Эрдэнэгэрэл Ц.Насанбуян

